# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр Дугаар А/121 Номгон

**Баянхонгор аймгийн хэмжээнд ой хээрийн түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 22 дугаар зүйлийн 22.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, Улсын Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "Эрсдэлийн үнэлгээ ирүүлэх тухай" 11 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн хэмжээнд ой, хээрийн түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Тус үнэлгээг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

624010221

D:\2024 ON\Zakhiramj\Захирамж.docx

Аймгийн Засаг даргын ...4.оны...02 дугаар сарын
29.-ний өдрийн ...121... дугаар захирамжийн хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|---|---|
| Э.Ганзориг | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |

Гишүүд:

| | |
|---|---|
| Т.Норовринчин | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| Б.Жамъяндорж | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн |
| Б.Магвансүрэн | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Зам тээврийн хяналтын улсын ахлах байцаагч |
| Ч.Эрдэнэбат | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Ч.Сарайдамба | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагч |
| Э.Адъяасүрэн | Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга |
| А.Булганчимэг | Эрүүл мэндийн газрын Яаралтай болон гамшиг, анхан шатны тусламж хариуцсан мэргэжилтэн |
| Б.Зүгдоржав | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал судалгаа, шинжилгээ, төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтэн |
| Б.Батдэлгэр | Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн Хөдөлмөр, хамгааллын инженер |
| Ж.Дэлгэрмаа | Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны улсын байцаагч |
| Ц.Баасанбат | Баянхонгор сумын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн |
| Г.Нансалмаа | Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн |
| | Сумдын Засаг дарга нар |

Нарийн бичиг:

| | |
|---|---|
| Д.Энхсайхан | Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч |

________оОо________